

**Орон нутгийн өмчийн газарт хийгдсэн шалгалтаар илэрсэн зөрчил,
дутагдал, шалтгаан**

1. Бараа материалын тайлан огт гаргадаггүй, жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогч нь өөрөө авсан шатахуундаа тааруулж бичдэг, агуулахын бүртгэл хөтлөөгүй, сургалтад зарцуулсан хүнс материалын зарцуулалтын тайлан огт байхгүй, тушаалгүй, томилолтын удирдамж, томилолтоор ажилласан тайлан огт байхгүй, амралтын мэдэгдэлгүйгээр амралт бодсон байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д / Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, мөн хуулийн 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно./, 13.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг

2. Цалингийн тооцооны хүснэгт болон гарт олгох хүснэгт дээр гарын үсэг зурж баталгаажуулдаггүй

3. Шилэн дансны нэгдсэн сайтад Орон нутгийн өмчийн газар нь 2016 онд 145 мэдээлэл байршуулахаас 120 мэдээлэлийг хугацаа хоцороож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д /Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 сарын 25-ны өдрийн дотор, сар, улиралын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор/, мөн хуулийн 8.2-д /Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ/ заасан заалтуудыг

4. 2015 оны 12 сарын 23-ны 80 тоот төлбөрийн хүсэлтээр томилолт бодож олгохдоо буудалд байрласан баримтгүйгээр 180000 мянган төгрөгийг олгосон байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг

5. 2016 оны 12 сарын 23-ны 74 тоот төлбөрийн хүсэлтээр 867786.52 төгрөгийг Төрийн банкны 120000390032 тоот дансанд цалингийн зардлаас шилжүүлсэн байна. Дээрхи данснаас Ц.Батжаргалд 120000101452 тоот дансанд 287102,05 төгрөг, Д.Уламбаярт 120000228140 тоот дансанд 253425,49 төгрөг, Ц.Энхжаргалд 360000120659 тоот дансанд 327158,98 тус тус оржээ. 2016 оны үр дүнгийн урамшуулал олгох 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/11 дүгээр тушаалд дарга Ц.Батжаргал өөрийн нэрийг оруулан 345805 төгрөгийн урамшуулал авсан нь аймгийн Засаг даргын 2016 оны 12 сарын 26-ны А/559 тоот захирамж, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолыг

6. Аймгийн засаг даргын 2016 оны 07 сарын 08-ны өдрийн А/327 тоот захирамжаар байгууллагын дарга асан Ц.Энхжаргалд олгогдох ёстой 1 сарын үндсэн цалинтай тэнцэх /790516 төгрөг/ урамшуулалыг олгоогүй

7. Нягтлан бодогч нь 2016 оны 12 сарын 21 өдрийн 68 тоот төлбөрийн хүсэлтээр 12 сарын цалинг бодож олгохдоо өөрийн амралтын цалинтай давхардуулан ажил олгогчийн шийдвэргүйгээр цалин илүү /463184 төгрөг/ бодож авсан байгаа нь Монгол

улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д / Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг

8. 2015 оны 02 сарын 10-ны 6 тоот төлбөрийн хүсэлтээр нягтлан бодогч нь 2-р сарын цалин дээр нэмж 160000 төгрөгний цалингийн урьдчилгаа авсан боловч 3-р сарын цалингаас 80000 төгрөгийг нь суутгаж 80000 төгрөгийг 4-12 сард суутгаагүй, тайланд авлагаар бүртгээгүй орхигдуулсан байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.2-д /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ заасан заалтуудыг

9. 2015 онд 830л бензин, 2016 оны 1-9 сард 382л бензин, 10-12 сард 258л бензин аймгийн төв дотор УАЗ-69 27-50БУЛ, Соната-6 01-12БУЛ зэрэг автомашинд хийж зарцуулсан боловч ямар албан ажилд явсан нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд илэрч, 5 актаар 1859505 төгрөгний төлбөр тогтоож, зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ШАЛГАСАН

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ